


11 Page



12 Page



13 Page

Адам ба Ева

-Adam and Eve-

Тайлбарлагч Еден цэцэрлэгт цэнгэг устай гол урсдаг байсан ба төрөл бүрийн мод, цэцэгсээр дүүрэн байв. Энэ цэцэрлэгийн амьтад ч бас хоорондоо эвтэй найртай амьдардаг байлаа. Еден цэцэрлэгийн голд амийн мод болон сайн мууг мэдүүлэгч мод ургадаг байлаа. Бурханы бүтээж өгсөн Еден цэцэрлэгт тэд аз жаргалтай амьдарч байв.

Бурхан “Цэцэрлэгт байгаа бүх модны жимснээс идэж болох боловч цэцэрлэгийн голд байгаа сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэж үл болно. Тэр жимсийг идвэл та нар зайлшгүй үхэх болно.”

Адам “За, ойлголоо Бурхан минь.


Тайлбарлагч Энэ цэцэрлэгт ганцаараа амьдрах нь Адамд маш их уйтгартай байсан тул Бурхан түүнийг унтаж байхад нь хавирганаас нь авч эмэгтэй хүнийг бүтээв. Тэгээд тэр эмэгтэйд Ева гэж нэрлэжээ. Адам Ева хоёр нүцгэн байсан ч бие биенээсээ ичсэнгүй.

Тайлбарлагч Гэтэл нэгэн өдөр могой Ева дээр ирээд
Могой “Энд байгаа бүх модны жимснээс Бурхан идэж болохгүй гэсэн үү?
Ева “Үгүй ээ, энд байгаа бүх модны жимснээс идэж болох боловч цэцэрлэгийн голд байгаа жимснээс идэж болохгүй, хүрч ч болохгүй гэсэн. Хэрэв идэх юм бол үхэх болно гэж Тэр айлдсан шдээ.


Могой “Хүүе, үгүй шүү, тийм биш. Нэг л удаа идээд үз! Сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идвэл огтхон ч үхэхгүй. Харин ч нүд чинь нээгдэж Бурхантай адил болж, юу сайн, юу муу гэдгийг мэддэг болно.

Ева “Тэр ...тийм гэж үү?
Могой “Тийм гээд байхад чинь дээ! Тэр жимсийг хардаа ..ямар гоё амттай харагдаж байнаа..(амтархан шүлсээ залгина)

Тайлбарлагч Могой Адам Ева хоёрыг хуурч, Бурханы үгэнд дуулгаваргүй хандуулж сайн мууг ялгах модны жимснээс идүүлснээр гэм нүгэлд унагаах хорон муу санаа агуулж байлаа. Ева сайн мууг мэдүүлэгч модонд очоод харахад жимснүүд нь үнэхээр идчихмээр амттай харагдаж байлаа. Идвэл зайлшгүй үхнэ гэсэн Бурханы үгийг тэр даруй мартсан байлаа. Ева эцэст нь жимснээс аваад идчихэв. Тэгээд Адамд өгөхөд тэр бас иджээ. Гэтэл сонин зүйл болжээ. Адам, Ева хоёр бие биенээ нүцгэн байгааг хараад ичицгээв. Тэгээд тэд биеэ навчаар далдлан модны ард нуугджээ. Энэ бүх зүйлийг мэдсэн Бурхан маш их гуниглав. Бурхан Адамын дэргэд хүрч ирээд:



14 Page



15 Page

Бурхан “Адамаа, чи хаана байна вэ? Бүү ид гэж тушаасан модны жимснээс чи идсэн үү?”

Адам “Бурхан минь, тэр эмэгтэй надад тэр жимснээс өгөөд, би идчихлээ”

Бурхан “Ева, чи яаж байгаа чинь энэ вэ?”

Ева “Бурхан минь, могой намайг хуурснаас болоод би идсэн юм”

Тайлбарлагч Бурхан, Өөрийнх нь тушаалыг сахиагүй Адам, Ева хоёрт мөн тэр хоёрыг хуурсан могойд шийтгэл оноожээ.

.....

Бурхан “Могой, чи хэвлийгээрээ мөлхөж насан туршдаа тоос шороо идэж амьдрах болно”

“Эмэгтэй хүн чиний жирэмсний зовлонг Би үлэмж ихэсгэж, чи маш их өвдөж хүүхэд төрүүлэх болно” “Эрэгтэй хүн чи насан туршдаа духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж идэх болно. Үхэхдээ тоос шороондоо буцаж очих болно”

Тайлбарлагч гэж айлдав. Бурхан тэр хоёрт арьсан дээл хийж өмсгөөд Еден цэцэрлэгээс хөөн явуулжээ. Тэр хоёр Бурханы тушаалыг зөрчсөн ч Бурхан тэр хоёрт хайраар хандсан нь энэ байлаа. Адам, Ева хоёр хийсэн хэргээсээ болж Еден цэцэрлэгийг гунигтайгаар орхин оджээ. Тэгээд он жилүүд өнгөрсөөр тэд урт удаан амьдарч Бурханы хэлсний дагуу тэд үхэж, газар шороондоо буцан очсон бөгөөд дахиад хэзээ ч Еден цэцэрлэг рүү очих боломжгүй болжээ.